



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны III байр
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09
E-mail: ub_info@inspection.gov.mn
http://www.ub.inspection.gov.mn

Г УРГАМАЛ, УРГАМЛЫН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ
ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ БЭЛТГЭН
НИЙЛҮҮЛЭХ, ХАДГАЛАХ, САВЛАХ,
ХУДАЛДААЛАХ ЧИГЛЭЛЭЭР
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДЭД

2017. 02. 15 № 02-01/547.
танай _____ -ны № _____ -г

Г Мэдэгдэл хүргүүлэх тухай Г

Нийслэлийн нутаг дэвсгэр дээр ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, импортлох, тээвэрлэх, хадгалах, худалдаалах чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчид нь Ургамал хамгааллын тухай, Таримал ургамлын үр, сортын тухай, Тариалангийн тухай, Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Органик хүнсний тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, заавар, стандартыг үйл ажиллагаандаа заавал мөрдөж ажиллахыг мэдэгдье. Үүнд:

1. Дотоодод тариалагдсан ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн нь орон нутгаас гарал үүслийг нь тодорхойлсон гэрчилгээ авсан байна.
2. Импортоор орж ирсэн ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн нь хилийн мэргэжлийн хяналт шалгалтанд хамрагдсан, гарал үүсэл, чанар, хорио цээр, импортын гэрчилгээтэй байна.
3. Итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн, сорилын дүнг авсан байна.
4. Тухайн бүтээгдэхүүний онцлогт тохирсон температур, агаарын харьцангуй чийгийн шаардлагыг ханган хадгалах, зориулалтын хөргүүртэй эсвэл бүхээгтэй тээврийн хэрэгсэлээр гадны бохирдол үүсэх нөхцлөөс сэргийлж бүтээгдэхүүнийг бусад бараа таваартай нийлүүлэхгүй тээвэрлэнэ.
5. Ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зохих зөвшөөрөлтэй цэгт, эрүүл ахуй, орчны ариун цэврийн шаардлагыг хангаж, худалдагч эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан, зориулалтын баталгаажсан жин хэмжүүр, тоног төхөөрөмжийг ашиглан, гарал үүсэл тодорхой, шинжилгээ баталгаажилтанд хамрагдсан, хаяг шошгонд тухайн бүтээгдэхүүний тухай мэдээллийн бүрэн тусгасан бүтээгдэхүүнийг иргэдэд худалдаална.
6. Иргэн, аж ахуйн нэгж нь ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний

1150500216

ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөлтийг батлагдсан аргачлалын дагуу хөтөлж хэвшинэ.

7. Шаардлага хангахгүй бүтээгдэхүүнийг өөрсдийн санаачлагаар буцаан авах, мэргэжлийн хяналтын байгууллага, олон нийтийн сүлжээ, хэрэглэгчийн мэдээллийн дагуу буруу шошголсон, хуурамч, аюулгүйн үзүүлэлтийн шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг татан авч, татан авсан тухай мэдээллийн мэргэжлийн хяналтын байгууллагад ирүүлж, шийдвэрлүүлнэ.

8. Ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, боловсруулах, савлах, худалдаалах бүх үе шатны үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүд дээрх бүх шаардлагыг дотоод хяналтаараа хянан, иргэдэд аюулгүй бүтээгдэхүүнийг нийлүүлэх шаардлагатай.

9. Худалдаа үйлчилгээ эрхлэгч нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн 2009 оны 63-р тогтоолоор батлагдсан "Хот тохижилт, цэвэрлэгээний талаар байгууллага, иргэн, аж ахуйн нэгжээс дагаж мөрдөх журам"-ын 2.1, 2.2, 2.3 дах заалтуудын дагуу үйл ажиллагаа эрхэлж буй газрынхаа орчмын 50м болон дүүргээс тусгайлан олгосон талбайг цэвэрлэж хэвших шаардлагатай.

10. Нийслэлд үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжүүд "Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх дэглэм, хэрэгжүүлэх арга хэмжээ"-ний зөвлөмжийг мөрдөж ажиллана.

Дээрх бүх шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллаагүй тохиолдолд Ургамал хамгааллын тухай, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн дагуу хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгож, үйл ажиллагааг нь зогсоох, шаардлага хангаагүй түүхий эд, бүтээгдэхүүнийг устгах зэрэг торгуулийн арга хэмжээ авна.

ДАРГА



Л.ЭРДЭНЭЧУЛУУН